

БАЙГАЛИЙН БҮСҮҮД ДЭХ ЖИЖИГ НУТАГ ДЭВСГЭР БҮХИЙ СУМДЫН ГАЗАР АШИГЛАЛТ

(Дархан уул аймгийн Орхон, Говьсүмбэр аймгийн Баянтал,
Дорноговь аймгийн Замын-Үүд сумдын жишээн дээр)

Я.Баасандорж, А.Энхбаатар, Н.Хишигсүрэн

Геоэкологийн хүрээлэн, Газрын нөөц, газар ашиглалтын салбар

Abstract

The Orkhon soum has an area of 47787 ha, the Bayantal soum covers 91606 ha and the Zamiin-uid soum 48680 ha. These soums have comparatively small areas compared to others throughout Mongolia.

These three soums support many different land uses due to the influences of varying socio-economic conditions and natural environments. For example: the Orkhon soum area contains primarily agricultural land use with crops such as potatoes and other vegetables being produced. This area has long been used for agricultural purposes and the tradition continues. The Bayantal soum on the other hand is used mainly for livestock grazing. The Zamiin-Uud soum is again different, as it is more urbanized with many cities, villages and other settlements. This soum lies on the border with China and its economy has benefited from the trade passing through this area.

Түлхүүр үгс: Газрын нэгдмэл сан, газар ашиглалт, байгалийн бүс

Оршил

Монгол улсын нийт нутаг дэвсгэр засаг захиргааны нэгжид буюу нийслэл, 21 аймаг, 330 гаруй сумдад хуваагддаг. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хамгийн доод нэгж нь сум, хороо бөгөөд нэг сум дунджаар 250.0-300.0 мянган га газар нутагтай.

Сүүлийн жилүүдэд нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ хамгийн багад тооцогддог Дархан-Уул аймгийн Орхон, Говьсүмбэр аймгийн Баянтал, Дорноговь аймгийн Замын-Үүд сумдын газар ашиглалтын байдалд үнэлгээ дүгнэлт хийх, ижил төстэй болон ялгаатай байдлыг харьцуулах судалгаа хийсэн болно. Нутаг дэвсгэрийн хэмжээ хэт жижигрэх нь экологийн болон нийгмийн сөрөг үр дагаварт хүргэдгийг судлаачид бүтээлдээ дурьдсан.

Хотууд болон төв замаас алслагдсан бэлчээрийн бүрэн биш нутагтай, хүн ам цөөнтэй, мал аж ахуйгаас өөр орлогогүй сумдын оршин суугчид нь хот суурин тийш “их нүүдэл” хийж өөрийн сумдаа өөрсдөө татан буулгаж байна [1]. Энэ байдал алслагдсан сумдад нийтлэг ажиглагдах боловч бидний судалгаа хийсэн сумуудад хүн ам шилжин нүүх биш харин шилжин ирж суурьших, дамжин өнгөрөх нь их байдаг онцлогтой.

Судалгааны материал, аргазүй

“Хээрийн бүсийн бэлчээрийн экологи ба газар ашиглалтын менежмент” сэдэвт суурь судалгааны ажлын хүрээнд дээрхи 3 сумын газар ашиглалт, газрын төлөв байдлыг судалсан билээ. Эдгээр сумууд нь ойт хээр, хээр, говийн бүсэд хамрагдах бөгөөд дэд бүтцийн хөгжил сайн.

Хээрийн судалгааг явуутын аргаар хийсэн бөгөөд хөрс, ургамлын бичиглэл хийж дээж авах, газар ашиглалтын одоогийн байдал, өөрчлөлтийг хэмжилт хийж, газарзүйн мэдээллийн системийн ArcGIS, ArcView программ ашиглан тоон мэдээлэлд шилжүүлсэн.

Судалгааны үр дүн

Манай улсын ойт хээр, хээр, говийн бүсэд босоо тэнхлэгийн дагуу байршилтай хамгийн бага нутаг дэвсгэртэй сумуудыг сонгож авсан юм.

Байгалийн бүсийн хувьд ялгаатай байрлал бүхий жижиг нутаг дэвсгэртэй сумдын газар ашиглалтын судалгаа хийж өөр хооронд нь харьцуулан үнэлгээ өгсөн.

1 дүгээр зураг. Судалгаанд хамрагдсан 3 сумын байршил

1 дүгээр хүснэгт

Газрын нэгдмэл сангийн ангилал (2008 он)

᠐᠗᠑ᠠᠭᠢ ᠶᠢ ᠶᠢ	ᠠᠠᠳᠣᠠᠢ -ᠣᠪᠡ ᠠᠡᠢ ᠠᠡᠢ ᠢ ᠳᠣᠢ ᠢ ᠨᠣᠢ		ᠠᠢ ᠠᠢᠨᠵᠢ ᠠᠶᠢ ᠠᠡᠢ ᠠᠡᠢ ᠠᠶᠢ ᠣᠠᠡ ᠨᠣᠢ		ᠠᠢ ᠳᠢ ᠢ ᠠᠢ ᠠᠢ ᠠᠡᠢ ᠠᠡᠢ ᠴᠠᠢ ᠠᠢ - ᠵᠠ ᠨᠣᠢ	
	ᠢ ᠶᠢ .ᠠᠠ	ᠳᠣᠠᠢ	ᠢ ᠶᠢ .ᠠᠠ	ᠳᠣᠠᠢ	ᠢ ᠶᠢ .ᠠᠠ	ᠳᠣᠠᠢ
ᠠᠵᠠᠠ	47.7	100.0	91.6	100.0	48.6	100.0
ᠣᠠᠠ-ᠢ ᠠᠠᠴᠠᠳ	44.3	92.8	87.6	95.7	17.7	36.4
ᠠᠶᠡ-ᠶᠡᠳᠡᠢ ᠠᠠᠴᠠᠳ	40.6	91.5	87.6	100.0	17.7	100.0
ᠣᠠᠳᠡᠠᠡᠢ ᠠᠡᠢ ᠠᠠᠴᠠᠳ	0.9	2.2	-	-	-	-
ᠣᠠᠡᠡᠢ ᠠᠡᠢ ᠣ ᠠᠡᠠᠡ	2.1	4.7	-	-	-	-
ᠠᠣ ᠠᠳᠣ ᠨᠠᠢ ᠠᠠᠴᠠᠳ	0.7	1.6	-	-	-	-
ᠣᠢ ᠣ, ᠣᠢ ᠨᠠᠢ ᠢ ᠠᠣᠨᠠᠠ ᠨᠣᠣᠳᠡᠢ ᠠᠠᠴᠠᠳ	1.1	2.4	2.0	2.2	1.0	2.2
ᠴᠠᠢ , ᠣ ᠣᠠᠢ ᠨᠵᠡᠶᠢᠶᠢ ᠡᠡ ᠠᠠᠴᠠᠳ	1.2	2.6	1.1	1.2	1.2	2.5
ᠢ ᠡᠢ ᠨᠠᠢ ᠠᠵᠣᠡᠡ ᠠᠠᠴᠠᠳ	0.08	0.17	-	-	-	-
ᠣᠢ ᠠᠢ ᠨᠠᠢ ᠠᠵᠣᠡᠡ ᠠᠠᠴᠠᠳ	1.0	2.0	-	-	-	-
ᠣᠡᠨᠢ ᠢ ᠣᠣᠨᠠᠡ ᠣᠶᠣᠶᠠᠶᠢ ᠡᠡ ᠠᠠᠴᠠᠳ	0.01	0.03	0.8	0.9	28.7	58.9

Хүснэгтээс үзэхэд ойт хээрийн бүсэд байрлах Орхон сумын нийт нутгийн 92.8%, хээрийн бүсэд байрлах Баянтал сумын нийт нутгийн 95.7%, говийн бүсэд орших Замын-Үүд сумын хувьд нийт нутгийн 36.4% нь бэлчээрт ашиглагдаж байна. Мөн газар ашиглалтын бусад төрлийн эзлэх талбай сум бүрд өөр өөр байгаа нь байгалийн бүсийн нөхцөл, нийгэм-эдийн

засгийн онцлогийг харгалзан газар ашиглалтын бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ер нь орон нутгийн хэмжээнд экологийн нөхцөлтэй уялдуулсан газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх арга туйлын хоцрогдолтой байгаагаас дэд бүтэц сайтай, жижиг нутаг дэвсгэр бүхий эдгээр сумдын хөгжлийн ирээдүй, чиг хандлага тодорхой бус байна.

Бүс нутгийн онцлог ялгааг харгалзан хөдөө аж ахуйн газрын ашиглалт, хамгаалалтын бодлогыг зөв зохистой тодорхойлох нь газрын чанарын буюу экологийн төлөв байдлыг үндэслэн газрын төлбөрийн оновчтой хувилбар бий болгох ач холбогдолтой.

Сумдын газар ашиглалтын онцлог:

Орхон сум: Дархан-Уул аймгийн Орхон сум нь нийт 47787 га нутаг дэвсгэртэй бөгөөд үүнээс 92.8 хувийг ХАА-н газар, 2.4 хувийг хот, тосгон бусад суурины газар, 2.6 хувийг зам, шугам сүлжээний газар, 0.17 хувийг ойн сан бүхий газар, 2.0 хувийг усны сан бүхий газар, 0.03 хувийг улсын тусгай хэрэгцээний газар тус тус эзлэж байна. Тус сум нийт нутгийнхаа 1.8 хувийг тариаланд, 4.6 хувийг хадлангийн зориулалтаар ашигладаг. Тариалангийн ихэнхи талбай нь усалгаатай бөгөөд түүнд төмс, хүнсний ногоо тариалдаг. Орхон сум нь экологийн харьцангуй тааламжтай бүсэд оршдог бөгөөд усны сан болон ойн сангийн газартайгаар бусад хоёр сумаасаа давуу юм.

Баянтал сум: Говьсүмбэр аймгийн Баянтал сум нь нийт 91606 га нутаг дэвсгэртэй бөгөөд үүнээс 95.7 хувийг ХАА-н газар, 2.2 хувийг хот, тосгон бусад суурины газар, 1.2 хувийг зам, шугам сүлжээний газар, 0.9 хувийг улсын тусгай хэрэгцээний газар тус тус эзлэж байна. Хөдөө аж ахуйн газар нь бүгд бэлчээрт ашиглагддаг. Хөрс, ургамлан нөмрөг ч бэлчээрт ашиглахад илүү тохиромжтой юм.

Гэхдээ зэргэлдээх сумдын малчид отор нүүдэл хийх, нүүж ирэх, дамжин өнгөрөх зэргээр бэлчээрийн газрын ачааллыг нэмэгдүүлэх сөрөг үзэгдэл байнга гардаг. Тус сум бэлчээрийн талбайн хэмжээгээр Орхон сумаас 10.8 хувь, Замын-Үүд сумаас 59.3 хувиар их байна. Ойрын жилүүдэд тус сумын ихэнхи нутаг бэлчээрийн зориулалтаар ашиглагдах нь нэгэнт тодорхой тул бэлчээрийн менежментэд онцгой анхаарах шаардлагатай.

Замын-Үүд сум: Дорноговь аймгийн Замын-Үүд сум нь нийт 48680 га нутаг дэвсгэртэй бөгөөд үүний 36.4 хувийг ХАА-н газар, 2.2 хувийг хот, тосгон бусад суурины газар, 2.5 хувийг зам, шугам сүлжээний газар, 58.9 хувийг улсын тусгай хэрэгцээний газар тус тус эзлэж байна. Сумын нутаг нь говийн бүсэд байрладаг тул газар тариалан эрхлэх, хадлан хадах боломж байгалийн нөхцлөөс шалтгаалж нэн хязгаарлагдмал юм. Замын-Үүд сумын нийт нутгийн дийлэнх хэсэг нь тусгай хэрэгцээний зориулалттай газарт ашиглагддагаар нилээд онцлогтой юм.

ХАА-н газар нь бүгд бэлчээрийн газар бөгөөд бэлчээрийн усан хангамж нь зөвхөн цөөхөн гүний худгаар хангагддаг тул худгийн орчмын бэлчээр талхлагдах нөхцөл болдог. Түүнчлэн Замын-Үүд сум манай орны өмнөд хилийн томоохон боомт тул том даацын авто машины хөдөлгөөн ихтэй байдаг нь эмзэг тогтоцтой хөрс, ургамлын нөмрөг доройтолд орох хүчин зүйл болдог. Ер нь Замын-Үүд сумын төв нь элсэнд дарагдсан, хүний болон техникийн нөлөөгөөр үүссэн цөлжилтийн шинж хүчтэй илэрсэн.

Судалгаанд хамрагдсан сумдын байгалийн болон
нийгэм-эдийн засгийн зарим онцлог

	ᠴᠢᠵᠢᠭᠡᠭᠡᠨ	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	ᠴᠢᠵᠢᠭᠡᠭᠡᠨ
	ᠠᠭᠢᠨᠠᠭᠢᠨᠠᠭᠢᠨ ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ			
1	ᠠᠭᠢᠨᠠᠭᠢᠨᠠᠭᠢᠨ ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ
2	ᠠᠭᠢᠨᠠᠭᠢᠨᠠᠭᠢᠨ ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	320	180	110-133
3	ᠠᠭᠢᠨᠠᠭᠢᠨᠠᠭᠢᠨ ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	1.7	2-2.5	3.5-4.0
4	ᠠᠭᠢᠨᠠᠭᠢᠨᠠᠭᠢᠨ ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	0.9	1.9	3.3
5	ᠠᠭᠢᠨᠠᠭᠢᠨᠠᠭᠢᠨ ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	600-1200	1100-1400	940-1110
	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ			
1	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	1994	1994	1994
2	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	47787	91606	48680
3	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	3000	892	9665
4	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	29888	21919	6584
	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ			
	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	275	200	715
	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	45	20	203
	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ
	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	+	+	+
	ᠶᠡᠨᠲᠡᠨᠢᠨ	+	+	-

Хүснэгтээс үзэхэд байгаль-уур амьсгалын нөхцөл, нийгэм-эдийн засаг, дэд бүтцийн хөгжлөөрөө сум бүр харилцан адилгүй байна. Ойт хээрийн бүсийн Орхон сумын нутагт жилд дунджаар 320 мм хур тунадас ордог бол говийн бүсийн Замын-Үүд сумын нутагт 110-133 мм хур тунадас орж байна. Жилийн дундаж температур Замын-Үүдэд 3.3^oC байхад Орхонд 0.9^oC байна. Орхон сум нь ойт хээрийн бүсийн тааламжтай уур амьсгалын нөхцөлд байгаа бол Замын-Үүд сум говь цөлийн хатуу ширүүн нөхцөлд байрлаж байна. Харин Баянтал суманд уур амьсгалын үзүүлэлт дээрхи сумуудын дундаж хэмжээнд байна. Газрын гадаргын төрх байдлаар Баянтал, Замын-Үүд сумд хотгор гүдгэрийн ялгаа бага боловч нийтдээ өндөрлөг гадаргатай бол Орхон сумын нутаг харьцангуй нам дор байрлалтай боловч гадаргын хотгор гүдгэрийн ялгаа ихтэй байна. Судалгаанд хамрагдсан сумдын газар нутгийн хэмжээ нь 47.7-91.6 мян/га талбай байгаа нь харьцангуй бага нутаг юм. Эдгээр сумдын хамгийн их хүн амтай нь Замын-Үүд сум бол Баянтал сум 800 гаруйхан хүн амтай байна. Малын тоо толгойгоор Замын-Үүд сум 6.5 мян/толгой малтай бол Баянтал, Орхон сумд 21.9-29.9 мянган толгой малтайгаараа ойролцоо байна. Дэд бүтцийн хөгжлийн түвшин, аймаг, нийслэлээс алслагдсан байдлаараа, Баянтал, Орхон сумууд ойролцоо бол Замын-Үүд сум хол байршилтай байна. Иймд дээрхи байгалийн нөхцөл, сумын газар ашиглалтын онцлогийг харгалзан жижиг нутаг дэвсгэр бүхий сумын онцлогт тохирсон бодлогыг онцгойлон анхаарах шаардлагатай.

Орхон, Баянтал, Замын-Үүд сумдад Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу иргэдийн гэр бүлийн хэрэгцээнд өмчлүүлсэн газрын хэмжээ ч харилцан адилгүй байна.

1 дүгээр график. *Өмчлүүлсэн газар, га*

Графикаас үзэхэд, Орхон сумын иргэд газраа өмчилж авах ажилд нилээд идэвхитэй хамрагдсан байхад Замын-Үүд сумын иргэд хангалтгүй хамрагдсан байна. Замын-Үүд сумын хувьд газар өмчлөл бага хэмжээтэй байгаа нь хилийн боомт, худалдааны чөлөөт бүсийн нөлөөгөөр тус суманд түр суурьшсан иргэдийн тоо олон байгаатай холбоотой.

Сумдын адил төстэй талууд

Судалгаанд хамрагдсан эдгээр сумд нь газар нутгийн хувьд жижиг хэмжээтэй, дэд бүтцийн хөгжил харьцангуй сайн, улсын чанартай, засмал болон төмөр зам дайран өнгөрдөг, засаг захиргааны нэгжийн хувьд 1994 онд сум болж зохион байгуулагдсан, Баянтал болон Замын-Үүд сумдад эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдаж буй зэрэг хоорондоо адил төстэй шинжүүд олон байна.

Дүгнэлт

Манай орны байгалийн бүсүүд нь ойт хээр, хээр, говь цөлд шилжих тутам газрын бүтээмж, чанар буурч, экологийн хувьд маш эмзэг тогтоцтой болдог. Энэ онцлогоос хамаарч дээрхи сумдын газар ашиглалтын хэлбэр өөрчлөгдөж байна.

Судалгаанд хамрагдсан сумд нь газар ашиглалтын хэлбэр янз бүр боловч бэлчээрийн газар зонхилж байгаа тул газар ашиглалтын бодлогыг боловсруулахдаа бэлчээрийн газрын ашиглалт, хамгаалалтын хамгийн зохистой харьцааг нэвтрүүлэх хэрэгтэй.

Газар ашиглалтыг зөвхөн ХАА-д ашиглах чиглэлээр бус дэд бүтцийн хөгжлийг ашиглан эрчимжсэн газар ашиглалтын хэлбэрийг эдгээр сумуудад нэвтрүүлэх боломжтой.

Ашигласан ном, хэвлэл

[1]. ШУА-ын Газарзүйн хүрээлэн, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн шинэчлэлийн нийгэм-эдийн засгийн газарзүйн тандах судалгаа, УБ, 2007

[2]. ШУА-ын Геоэкологийн хүрээлэн, “Замын-Үүд сумдын газрын менежментийг боловсронгуй болгох нь” эрдэм шинжилгээний тайлан, УБ, 2003

[3]. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, УБ, 2008

[4]. Орхон, Баянтал, Замын-Үүд сумдын газрын нэгдмэл сангийн тайлан, УБ, 2008